

**Нэрт зохиолч Ч. Лодойдамбын уран бүтээлд орос хүмүүсийн дүрийг бүтээсэн нь  
(= Отображение образов русских людей в творчестве известного писателя Ч. Лодойдамбы)**

*Цоодол Шунхайн*<sup>1</sup>

<sup>1</sup>Ховдский государственный университет (г. Ховд, Монголия)  
докторант

© КалмНЦ РАН, 2020

© Цоодол Ш., 2020

**Аннотация.** В статье рассматривается отображение в произведениях известного монгольского писателя, общественного деятеля, лауреата государственных премий Чадраабалын Лодойдамбы образов русских людей. Помимо того, что писатель сумел художественными средствами показать на историческом отрезке времени результаты российско-монгольского сотрудничества, тем самым запечатлеть тот исторический отрезок времени, предельно ярко изобразил подвижничество простых русских людей, боровшихся за Монголию не щадя своей жизни и вложивших все силы и душу в развитие нашей страны. Тем самым монгольский автор получил оценку как писатель, наиболее художественно и самым подробнейшим образом отобразил русских людей в современной монгольской литературе. Среди его героев — русский доктор в повести «Коллектив нашей школы», работник Академии наук СССР, доктор геологических наук, профессор Николай Владимирович Панов в романе «На Алтае», революционер Петр, русский торговец Павлов в романе «Прозрачный Тамир» и др.

**Ключевые слова:** Чадраабалын Лодойдамба, Монголия, литература, образы русских людей, доктор, профессор Панов, торговец Павлов

**Благодарности.** Материалы статьи апробированы на Международной научной онлайн-конференции «Монголоведение в начале XXI в.: совре-

менное состояние и перспективы развития – II», проведенной при финансовой поддержке РФФИ (проект № 20-09-22004) и частичной поддержке гранта Правительства РФ (№ 075-15-2019-1879).

**Для цитирования:** Цоодол Ш. Нэрт зохиолч Ч. Лодойдамбын уран бүтээлд орос хүмүүсийн дүрийг бүтээсэн нь // Бюллетень Калмыцкого научного центра РАН. 2020. № 4. С. 305–314. (На монг.) DOI: 10.22162/2587-6503-2020-4-16-305-314

UDC 821.512.36

DOI: 10.22162/2587-6503-2020-4-16-305-314

## **The Representation of Images of Russian people in the Works of the Famous Writer Ch. Lodoydamba**

*Tsoodol Shunkhayin*<sup>1</sup>

<sup>1</sup> Khovd State University (Khovd, Mongolia)

Doctoral Student

© KalmSC RAS, 2020

© Tsoodol Sh., 2020

**Abstract.** The author of the article analyzes how the images of Russian people are reflected in the works of the famous Mongolian writer, public figure, laureate of state prizes Chadraabalyn Lodoydamba. The writer managed not only to show the results of Russian-Mongolian cooperation over the historical period of time, thereby capturing that historical period of time, he extremely vividly depicted the asceticism of ordinary Russian people who fought for Mongolia without sparing their lives and put all their strength and soul into the development of the country. Thus, the Mongolian author was assessed as a writer who gave the most artistic and most detailed images of the Russian people in modern Mongolian literature. Among his heroes is a Russian doctor in the story “Our School Staff”, an employee of the USSR Academy of Sciences, Doctor of Geological Sciences, Professor Nikolai Vladimirovich Panov in the novel “In Altai”, revolutionary Peter, a Russian merchant Pavlov in the novel “Transparent Tamir”, etc.

**Keywords:** Chadraabalyn Lodoydamba, Mongolia, literature, images of Russian people, doctor, professor Panov, a merchant Pavlov

**Acknowledgement:** The article was presented at the international scientific online conference “Mongolian Studies at the beginning of the 21<sup>st</sup> century: Current State and Development Prospects – II”, held with the financial support of RFBR (project № 20-09-22004) and partial support of the Russian Government Grant (№ 075-15-2019-1879).

**For citation:** Tsoodol Sh. The Representation of Images of Russian people in the Works of the Famous Writer Ch. Lodoydamba. In: *Bulletin of the Kalmyk Scientific Center of the RAS*. 2020. No. 4. Pp. 305–314. (In Mong.) DOI: 10.22162/2587-6503-2020-4-16-305-314

Шинэ цагийн Монголын уран зохиолд орос хүний дүрийг хамгийн тодорхой бүтээсэн зохиолч бол Ч. Лодойдамба ажээ. Түүний «Манай сургуулийнхан» туужийн орос эмчийн дүр, «Алтайд» романы СССР-ийн Шинжлэх ухааны академийн ажилтан, геологийн шинжлэх ухааны доктор, профессор Николай Владимирович Панов, «Тунгалаг Тамир» романы хувьсгалч Петр, орос худалдаачин Павлов нарын дүрийг шинэ аргаар цогцлоон бүтээжээ. Ингээд эдгээр дүрүүдийг хэрхэн бүтээснийг тодруулан авч үзье.

«Манай сургуулийнхан» зохиолд «Докторыг бид нар нягт хүрээлж аваад хэсэг харж зогсов. Энэ орос эмэгтэй бол хаанаас нь яаж харсан ч өөгүй бөгөөд чухамхүү сайн сайхан бүхний хуримтлал байв. Алтан шар үс нь наранд гялалзан туяарч байх нь жаргалын түмэн туяаг зүг бүхэндээ цацруулж байгаа юм шиг харагдаад шулуун хамры нь угт инээмсэглэн эргэлдэж байгаа цээлхэн сайхан хоёр цэнхэр нүдэнд нь муу санаа, муу явдлын зай ч үгүй мэт бодогдов» гэсэн байдаг бөгөөд ийм л сайхан сэтгэлт, гоо үзэсгэлэнт орос эмчийн энэ л дүр уншигчийн сэтгэлд тодхон үлддэг билээ.

Ер нь Ч. Лодойдамба зохиолчийн зохиолуудын нэг гол онцлог нь шинэ хуучин хоёрын тэмцлийг маш хурцаар, уран тодоор дүрсэлж дүрүүдийн хоорондын харьцааг зөрчил тэмцлийн дунд сөргөлдүүлэн гаргадаг нь тухайн дүрүүдийг улам тодорхой уран сайхан болгодог.

«Манай сургуулийнхан» туужийн орос эмчийн дүр ч ийм аргар шинэ үеийн боловсон эмнэлэг, шашны хуучин эмнэлэг хоёрын зөрчилдөөн, орос эмч, оточ Лувсан нарын үйл ажиллагаа, үзэл бодлын зөрөөг харьцуулан урлаж аль алиных дүрийг урласан байдаг.

Доктор гэж ямар хүн ирэх талаар Ням гүн, хүүхдүүд, Лувсан оточ нарын хооронд байнга болж байгаа яриа, анхны төсөөллүүд, орос эмч ирээд хүүхдүүдтэй хэрхэн харьцаж байгаа, эмчилгээний үр дүн, өөрөө цусаа өгч ухаан алдан унаж байгаа зэргээс сайхан сэтгэлтэй, хүнлэг чанартай орос эмчийн дүр улам бүр тодорч байна.

Зохиолд орос эмчийн талаар «...Би толгойгоо хүчлэн хөдөлгөж хараад цочин өндийв. Гэрт гурван хүн орж ирээд зогсож байв. Тэдний нэг нь Далхаанямбуу багш нөгөө хоёр нь үл таних хүн байлаа. Хоёулаа яг адил цагаан хувцастай бөгөөд нэг нь эрэгтэй монгол хүн, нөгөө нь эмэгтэй орос хүн байв. Хүүхдүүдийн босож чадах нь босож, өндийж чадах нь өндийв. Чулуун хөнжлөө нөмрөн гарч зугтаах гэснийг Далхаанямбуу багш барьж аргадан орон дээр нь суулгав. Харин Бурантаг хөдлөх ч үгүй дээш харан хэвтэж байлаа. Цагаан хувцастай орос хүүхэн бид нарыг гайхан харж байснаа инэмсэглээд хэдэн үг хэлэв. Би юу гэж хэлснийг ойлгосонгүй.

— Та нарыг доктор гуай сайн байна уу гэж байна гэж цагаан хувцастай хүн хэлэв. Бидний хэн нь ч дуугарсангүй. Тэр доктор хөдөлж, миний толгойг илсэнд, би цочин давхийв. Доктор давхийснийг мэдээд над руу харан толгойгоо сэжлэн инээмсэглэж,

— Ай, я яа я гэж хэлээд Доржийн орны дэргэд очив» [Лодойдамба 1977: 50] гэж гардаг. Ингэж анх доктор өвчтэй хүүхдүүдтэй уулзаж тэднийг үзэж эхэлдэг бөгөөд хүүхдүүд хагалж огтлохоос айж, зарим нь дургүйцвч багшийнхаа үгэнд орж үзүүлэхэд яагаа ч үгүй болохоор сэтгэл тайвширдаг.

«Гадаа ярьж байгаа үгнүүдийг цагаан хувцастай эрэгтэй хүн докторт хэлж өгөв бололтой. Докторын царай хувиран сайхан нүүрэнд нь тодорч байсан инээдэм ор сураггүй алга болов. Доржийн орон дээрээс босоод чагнуураа түргэн эвхэж өвөртлөв» [Лодойдамба 1977: 50]. Тэгээд үүд рүү явах гэтэл ууртай багш өмнөөс нь орж ирээд докторыг явуулж аль, эсвэл бид явна гэж их муухай

юм болж байгаа талаар ярихад түүнийг цагаан хувцастай эрэгтэй хүн орчуулж өгдөг. Тэгээд яахыг асуухад «буцсан ч яадаг юм...» гэсэн хариу сонсоод, «Юу ч болсон би явахгүй, би өөрөө ярина гэж доктор цагаан хувцастай хүнээр дамжуулан хэлээд шууд гэрээс гарлаа» [Лодойдамба 1977: 51].

Удалгүй доктор эргэж орж ирээд үзлэгээ хийхэд Бурантаг л шууд эсэргүйцэн хөөж зангидсан гараараа ээлжлэн цохиж, дэрэн дороосоо төмөр сэрээ гарган нүүр рүү нь цохин шархдуулдаг.

«Бид докторын тухай ярьж эхлэв. Монгол хүнийхээс өндөр хянган хамар, утаа болсон юм шиг шар үс, нилээд гүн аяганд эргэлдэж байгаа цог хорхой шиг хоёр цэнхэр нүдний нь тухай ярилцав. Тэр инээдээр эргэлдэж байгаа хоёр нүдний цаана хагалах, огтлох айхтар санаа оршиж байгаа шүү дээ гэж бодоход, тэр докторт бидний тааламжтай сэтгэлийг татах юм огтхон ч байсангүй билээ» гэжээ [Лодойдамба 1977: 53].

Эндээс үзэхэд орос хүнийг анх удаа ойроос харж байгаа хүүхдүүдэд харагдах гадаад төрх, тэгээд ч өөрсдийг нь хагалж огтлох байх гэж болгоомжилж байгаа хүний талаар тааламжгүй бодлоос харахад ч орос эмчийн дүр тодорч зохиолчийн мэдрэмж ур чадвараар уран дүр болох нь мэдрэгдэж байна. Хүүхдүүдэд янз бүрийн сайхан амттай хоол хийж өгөхийн зэрэгцээ, сонирхолтой юм ярьж, орос дуу зааж өгөх зэргээр хүүхдүүдэд элэгсэг дотно хандан тэдний итгэлийг хүлээж байдаг.

Уг зохиолд «Би олон сайхан дуучны гоё хоолойг сонсож, тэдний уран чадлыг бишрэн бахархаж байсан билээ. Гэвч би одоо хүртэл тэр докторын хоолой шиг яруу сайхан хоолойг сонсоогүй юм шүү» [Лодойдамба 1977: 62] гэсэн байдаг нь тухайн дүрийн бас нэгэн онцлогийг илэрхийлж байна.

Мөн, «Бурантаг «За» гэв. Гэтэл доктор инээсэн ч үгүй, баярласан ч үгүй, харин царай нь хувхай цагаан болж, нүд нь гөлөлзөн уруул нь чичирч байснаа Бурантагийг тэврэн аваад үнсэв», «Доктор хэдэн үг хэлэхэд цагаан хувцастай хүн докторын нөгөө гараас цус авч Бурантагийг урьдах ёсоор тарив. Ингээд докторын хоёр гараас ээлжлэн Бурантагийг хэд хэд дахин тарьсан билээ», «Гэтэл Бурантаг урт гэгч нь амьсгаа аваад, нүдээ нээж хөдлөлгүй,

нүүр рүү нь бөхийн ширтэж байгаа докторыг ажиглан харж байнаа «Доктор» гээд уруулаа хөдөлгөх нь надад инээмсэглэх мэт харагдав. Доктор доош унжуулсан толгойгоо өндийлгөв. Түүний дөлгөөн цэнхэр нүдэнд нь инээмсэглэл, баярлал, тодрох шиг болсноо, зовхи нь алгуур хумигдаж, бүхий л биеэрээ найгаснаа, Бурантагийн бугуйнаас бариатай хэвээрээ, хана руу пид гэтэл унав» [Лодойдамба 1977: 66].

Ийм л ач буянтай монгол түмний төлөө бие сэтгэлээ үл хайрлан зүтгэж байгаа Оросын жирийн эмч бүсгүйн дүр манай уран зохиолын алтан хуудсанд авьяас билигт зохиолчийн гэгээн ухааны ураар бүтээгдсэн байна.

Герасимович Л. К. «Аюултай хүнд нөхцөлд монголын хүүхдүүдийн төлөө амь биеэ үл хайрлан тэмцсэн орос эмч бүсгүйн дүрийг уг туужид гаргахдаа зохиогч тун ихээр хайрлан бичсэн байна» гэж тэмдэглэжээ [Герасимович 1965: 231].

Энэхүү туужид хүүхдүүдийн дүрийг бие биеэсээ ялгарсан онцлогтой, тэдний сэтгэл зүйг гайхалтай сайхан үзүүлсэн төдийгүй хэлж ярьж байгаа үгнээс нь хэн болохыг нь мэдэж болохоор, ялган танигдахаар сайхан дүрүүдийг бүтээжээ гэж үзэж байна. Тийм дээ ч орос эмчийн дүрийг улам тод харуулахад тэдний дүрийн нөлөө их байдаг нь харагдаж байна.

Одоо «Тунгалаг Тамир» романы Павлов, Петр нарын дүрийг хэрхэн урласныг авч үзье. Зохиолд, «Итгэлтийг даваан дээр бугагад тамхи татаж суухад морин тэрэгтэй орос ирээд зогсов. Богино тааран дээлтэй хууз сахалтай Павлов бууж, Түнхэлийн буриад аялгуугаар мэндлээд үхэр худалдан авах тухайгаа ярив.

— Орос чамд мөнгө байвал надад үхэр байна гэж Итгэлт хэлжээ.

— Баатар цагаан хааны буянаар чамайг хошуу нутагтай чинь худалдан авсан ч мөнгө байна. Хоёр зуун амбан шар байна уу? гэж Павлов асуув.

— Ердөө энэ үү. Тав хоногийн дараа хоёр зуун шар энэ даваан дээр туугаад ирье. Байдаг мөнгөө дэнслээд сууж байгаарай гэж Итгэлт хэлээд тэр хоёр салжээ», гэх буюу, «Павлов овооны өмнөх хавтгай чулуун дээр оросын гулдмай гэж урт цагаан мөнгө

гаргаж тавиад хангинуур сүхээр цавчлан цэгнэж өгөхдөө үсэрсэн хэлтэрхийн үүдийг авах нь битгий хэл харах ч үгүй байжээ. Энэ нь Итгэлтийн сэтгэлд үлэмж таалагдаж «их гарын панз бололтой» гэж бодож байсан билээ. Ингэж наймаа хийхдээ Павлов бодож ирснээсээ дөрвөн зуун лан хожсон бол Итгэлт хүнээс авсан зуун жар гаруй үхэр бүхнээс хоёр лан хожжээ» хэмээн өгүүлдэг [Лодойдамба 1977: 38].

Ийм хоёр хүн ингэж танилцан хамтарч эхэлдэг. Нөхөрт итгэдэг, том наймаа хийхээс буцдаггүй, зүрхтэй ховор монгол шүү гэж Павлов Итгэлтийг магтаж байдаг бол манай Павлов нүнжигтэй орос доо. Жаахан онгиргон болохоос биш, ёстой их гарын панзчин даа гэж Итгэлт Павловын тухай ярьдаг байв.

«За тэгээд наймаа сайн, олз омог их биз дээ? гэж Итгэлийн асуухад Павлов бардам инээмсэглэж «Бид хоёр олз олохгүй бол ямар аавын хүү олох билээ дээ» гээд хоёул чанга инээв.

Дээр ишилсэн хэсгүүдээс харахад орос худалдаачин Павловын ямархуу төрхтэй, ямар ааш зантай хүн болох дүр нь нилээн тод харагдаж байна.

Орос, Германы хооронд дайн гарсныг Павлов Итгэлтэд дуулгаад, «Одоо бид хоёр цөлхөөв гэдгийг...» гээд хоёр гарын алгаа дээш харуулан атгаснаа «ингэнэ» гээд тэр хэвээр нь дээлийнхээ хоёр ташааны уутанд хийжээ [Лодойдамба 1977: 98]. Эндээс түүний ямархуу хүн болох нь харагдана. Павлов цагаантны бослогод идэвхтэй оролцож улмаар Колчакийн цэрэгт ордог. Сибирийн партизануудад шахагдсан цагаантнууд Монгол руу оргон орж ирээд Павловын удирдлагын дор нэгдэн барон Унгернтэй холбоо тогтоож Павлов нэг хороог захирдаг. Павлов «нэг бол улаантнууд энэ хорвоо дээр амьдарна. Эсвэл би амьдарна. Бидэнд нэг нар байхгүй» [Лодойдамба 1977: 286] гэсэн үзэл бодолтой нэгэн. Үүндээ үнэнч явсаар баригдаж амиа алддаг.

«Зохиолч энэ дүрийг бүтээхдээ нэгдүгээрт тухайн үеийн монголын цаг төрийн байдалд оросын цагаантнууд хэрхэн нөлөөлснийг үзүүлэх, хоёрдугаарт хэрэв тэд ялсан бол монгол орон ямар замаар явах байсныг л илэрхийлэн харуулах зарчим бариталсан юм» судлаач Б. Ганбат тэмдэглэжээ.

«Тунгалаг Тамир» романд дүрслэгдсэн нөгөө нэг орос хүн бол хувьсгалч Петр. Тэрээр 1905 оны хувьсгалд оролцож нутаг заагдсан нэгэн бөгөөд хямд өртөгөөр Павловт зарцлагдаж яваа хүн. Монголчуудын дунд аж төрж ард түмнийг нь сайн танин мэдсэн бөгөөд улмаар орос оронд гарсан Октябрийн хувьсгалд идэвхтэй оролцож дараа монгол оронд цагаантныг эх орноосоо хөөхөд нь туслахаар улаан армийн нэгэн ангийн комиссараар ирж байна. Тэгээд хуучны танил Эрдэнэтэйгээ хамт тулалдаж явахдаа хувьсгал ялсны дараа улс орны хувь заяаг хааш нь хөтлөх, ард түмний сайн сайхны тусын тулд юу хийх учиртайг монгол нөхөртөө ойлгуулж, тус орныг гадаад дотоодын дайсны хөл үймээнээс цэвэрлэх ариун үйлсийн төлөө зүтгэж яваад амиа алдаж байгаа талаар романд өгүүлдэг.

Утга зохиол судлаач, доктор Г. Галбаяр «Орос хүний уужим сайхан сэтгэл, хүнлэг нинжин, ухаалаг чанар, гунихыг үл мэдэх хөгжүүн зан, холч хэрсүү алсын бодол, чигч ариун зорилго, түүнийгээ гүйцэлдүүлэх хатан зориг, хатуу тэвчээр цөм Петрийн дүрд цогцлон бүрдсэн байна» [Галбаяр 2004: 260] гэсэн бол доктор Л. Түдэв, «Тунгалаг Тамир»-ын алиа Петр... нар шиг хүнлэг зан чанартай, интернационалч хүмүүжилтэй хүмүүсийн дүр манай утга зохиолд улам бүр нэмэгдсээр байна» гэсэн дүгнэлт хийжээ [Утга зохиолын... 1988: 169].

Петр бол алиа наргианч зантай, нөхөрсөг сайхан сэтгэлтэй, эгэл энгийн нэгэн бөгөөд эрх чөлөөний төлөө шударга тэмцэгч, улс орны хөгжлийн талаар алсын бодлоготой ухаалаг хээгүй орос эр болох нь харагддаг. Монгол нөхөр Эрдэнэ нь «Петр бол зөвхөн алиа Петр биш шархдаж хэд хоног хаданд хэвтээд эдгэрэн нисэх гэж байгаа бүргэд шиг хүн бөгөөд үлэмж ухаан, тод эрмэлзлэлтэй эр» [Лодойдамба 2005: 95] гэж бодож байдаг.

Энэ бүхнээс Петрийн дүр уншигчдын сэтгэлд хоногшин үлдэж, хайрлагдаж байдаг бөгөөд Оросын ард түмэн, хувьсгалчдын үзэл санаа, үйл хэрэг, хүсэл эрмэлзлэл, эрх чөлөөний тэмцлийн нийтлэг төрхийг Петрийн дүрээр хураангуйлан үзүүлсэн байна.

Монголын анхны роман «Алтайд»-д гарч байгаа дүрүүд бол геологи хайгуулын шинэ салбарт ажиллаж байгаа шинэ хүмүүсийн



дүр бөгөөд тухайн салбарын ажил үйлсийн талаар өргөн олонд мэдлэг олгосон, хүүхэд залуу үеийг энэ ажил мэргэжилд уриалан дуудсан өндөр ач холбогдолтой байжээ.

Панов энгийн ажилчин байгаад сургуульд суралцаж эрдмийн хүн болсон бөгөөд Казакстанд чухал баялгийг нээж Сталины шагнал хүртсэн, геологийн шинжлэх ухааны доктор, монголын ард түмний сайн сайхны төлөө хөдөлмөр бүтээлээ зориулсан орос зөвлөлтийн хүмүүсийг төлөөлсөн дүр юм.

Тэрээр эх орны дайны урт замыг туулж монголын малчин ард Дамдингийн бэлэглэсэн хурдан борлог морийг унаж гавьяа байгуулж явсан дайчин эр. Эчнээ танил Дамдинтайгаа уулзаж, Алтайн чанадад хайгуул шинжилгээ хийн олон янзын бэрхшээл туулж монголчуудтай нөхөрлөж яваа, монгол хэл, ёс заншлыг сайн мэддэг, нөхөрсөг, түшиг тулгууртай, алиа хөгжөөнтэй, эрэлхэг зоригтой, цайлган цагаан сэтгэлтэй хээ шаагүй орос хүн юм. Түүний дүрийг ийм л байдлаар зохиолд тусгажээ. Панов Баяртай хамт чонотой хөөцөлдөж яваад нөхдөөсөө салж, угалз шуурганд орж, чонын сүрэгт бүслэгдэн явах хүнд үед энэ орос эрийн жинхэнэ хүн чанар, нөхрөө гэсэн халуун сэтгэл, амьдралын зовлон бэрхшээл туулсан арвин туршлага бүхэн илэрч уг дүрийг улам баялаг болгодог.

Судлаач Б. Ганбат «Зөвлөлтийн хүмүүс монголын ард түмэнд ийм ойр дотнын, ах дүүгийн сайхан сэтгэлээр хандаж, хайрлан халамжилж байдгийг бид сайн мэддэг бөгөөд ах, эгч нар минь хэмээн хүндэтгэн хайрладаг билээ. «Алтайд» романд Пановын дүрийг бүтээхдээ зохиолч чухам ийм сэтгэлээ илэрхийлэн гаргасан байдаг» гэжээ [Ганбат 1998: 203].

Ер нь өнөөгийн энэ цаг үеэс харахад тодорхой түүхэн цаг хугацаанд монгол, орос хоёр орны хамтын ажиллагааны үр шим ямар байсныг уран сайнхы аргаар нээн харуулсны дээр тэр цаг үеийг түүхэнд мөнхөлж, монгол эх орны төлөө амь хайргүй тэмцсэн, хөгжил цэцэглэлтийн үйлсэд бие сэтгэлээ зориулсан эгэл орос хүний дүрийг бүтээжээ гэж хэлж болно.

Эцэст нь дүгнэхэд, өнөөгийн энэ цаг үеэс харахад тодорхой түүхэн цаг хугацаанд монгол, орос хоёр орны хамтын ажиллагаа-

ны үр шим ямар байсныг уран сайнхы аргаар нээн харуулсны дээр тэр цаг үеийг түүхэнд мөнхөлж, монгол эх орны төлөө амь хайргүй тэмцсэн, хөгжил цэцэглэлтийн үйлсэд бие сэтгэлээ зориулсан эгэл орос хүний дүрийг монголын уран зохиолд хамгийн уран тодоор бүтээсэн байна.

### Ном зүй

- Галбаяр 2004 — *Галбаяр Г.* XX зууны Монголын уран зохиолын үечлэлийн асуудлууд. Улаанбаатар: изд-во, 2004.
- Ганбат 1998 — *Ганбат Б.* Монголын сонгодог зохиолч Чадраабалын Лодойдамба амьдрал, уран бүтээл. Сеул: изд-во, 1998.
- Герасимович 1965 — *Герасимович Л. К.* Литература Монгольской Народной Республики 1921–1964 годов. Л.: Изд-во Ленинградского университета, 1965. 311 с.
- Лодойдамба 1977а — *Лодойдамба Ч.* Түүвэр зохиол. Улаанбаатар: АБЯ-ны хэвлэл, 1977. 346 с.
- Лодойдамба 1977б — *Лодойдамба Ч.* Тунгалаг Тамир. I дэвтэр Улаанбаатар, 2005. Утга зохиолын... 1988 — Утга зохиолын шүүмжлэл-85. Улаанбаатар, 1988.